

## Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг  
Ханбогд сум

2017 оны 02-р сарын 15-16

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн (ГТЗ) хурал 2017 оны 02 дугаар сарын 15-16-ны өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд ГТЗ-ийн гишүүд, Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газрын чиглүүлэгч, Малчдын төлөөллийн гадаад дотоодын зөвлөхүүд, Оюу толгой ХХК-ийн орон нутгийн харилцаа, хуулийн хэлтсийн ажилтнууд оролцсон болно.

Энэ хурлаар Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг, Хөндлөнгийн шинжээчдийн багийн судалгааны ажил болох Ханбогд сумын малчдын ахуй амьжиргаа, нийгэм соёлын байдалд гарсан сүүлийн арав гаруй жилийн өөрчлөлт, үүнд Оюу толгой компанийн үйл ажиллагааны нөлөөлөл, нөхөн олговрын хөтөлбөр зохистой байсан эсэх талаар хараат бус үнэлгээ хийж дүгнэлт гаргах судалгаа, Ундай голын гольдрол өөрчлөлтийн улмаас үүссэн хам нөлөөллийн 2-р шатны судалгааны зөвлөмжийн хүрээнд гомдлыг шийдэхэд чиглэсэн ямар арга хэмжээг хэрэгжүүлж болох асуудлыг талууд хэлэлцлээ.

Хоёр өдрийн хэлэлцүүлгийн үр дүнд талууд судлаачдын гаргасан 28 зөвлөмжийн 18 зөвлөмжийг шууд хэрэгжүүлэхээр санал нэгтэй тохиров. Үүний дотор Ханбогд сумын малчин иргэдийн хамгийн их анхаарал татсан асуудал буюу нөхөн олговрын асуудлаар дараах гол тохиролцоонд хүрлээ. 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ, 2011 оны нөхөх олговрын гэрээнд хөөн хэлэлцүүлж орох хүсэлтээ нөхөх олговрын нэхэмжлэлийн хороонд тавих малчин өрхийн шалгуурыг тохиров. Тохирсон шалгуурын дагуу нэхэмжлэл гаргасан малчдын хүсэлтийг хэлэлцэх нэхэмжлэлийн хорооны үүргийг Зөвлөлийн дараагийн хурлаар хэлэлцэж батлах юм. Үүнээс гадна Ханбогд сумын нийт малчдад үр өгөөжөө авчрах үйл ажиллагааг нийтийн нөхөн олговрын хүрээнд урт ба богино хугацаанд хэрэгжүүлэхээр ерөнхийд нь тохироод байна.

Зөвлөлийн дараагийн хурлыг 2017 оны 3 сарын 22-нд хийхээр товлож, хэлэлцээрийг үргэлжлүүлэхээр боллоо.

### Ханбогд сумын Гурван талт зөвлөл

#### *Гурван Талт Зөвлөлийн тухай*

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.